

Хэрэгжүүлэгч:



ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖИЛ ТӨСӨЛ

БАРИМТ МЭДЭЭЛЭЛ

Төслийн нэр:

Залуучуудын хөгжил төсөл

Хэрэгжүүлэх хугацаа:

2013 – 2017 он

Төсөв:

ШХА: 4,700,000 шв.франк

Зорилтот бүлэг:

Залуучууд

Зорилтот бүс нутаг:

11 аймаг (Баян-Өлгий, Увс, Ховд, Завхан, Баянхонгор, Говь-Алтай, Орхон, Дархан-Уул, Өмнөговь, Дорноговь, Дорнод), Улаанбаатар хот

Хамтран санхүүжүүлэгч:

- Люксембургийн Засгийн газар
- НҮБ-ын Хүн амын сан

“Залуучуудын хөгжил” төсөл нь нийгэм, эдийн засгийн эрс өөрчлөлтөөс улбаатай хүндрэл бэрхшээлийг даван туулах чадварыг залууст төлөвшүүлэх, тэдний эмзэг өртөмгий байдлыг бууруулахад анхаарч байна. Ялангуяа, уул уурхайн бүс нутаг, хот суурин газар болон баруун аймгуудын нийгмийн үйлчилгээ зайлшгүй шаардлагатай залууст голлон анхаарлаа хандуулна. Төслөөс Монгол улсын хэмжээнд нийт 250,000 гаруй залуучуудын амьдрах ухаан чадварыг хөгжүүлж, тэдний хариуцлагатай, бүтээлч амьдрах чадварыг дээшлүүлнэ.



© Дастин Баргер

Залуучуудын хөгжлийн төвд залуус амьдрах ухаанд суралцаж байна

ҮНДЭСЛЭЛ

Эрүүл харилцаа, эрүүл гэр бүл, эрүүл нийгмийг дэмжихэд амьдрах ухааны чадварууд чухал ач холбогдолтой. Амьдрах ухааны боловсрол нь залуучуудын шийдвэр гаргах, бусдын эрх, сонголтыг хүндэтгэх, түүний дотор сэтгэл хөдлөлөө хянах, уур бухимдалаа удирдах чадварыг хөгжүүлдэг. Улмаар амьдрах ухааны чадваруудыг хөгжүүлэх нь хүйсийн тэгш бус байдал, жендэрт суурилсан хүчирхийллийг (ЖСХ) багасгахад шууд нөлөө үзүүлнэ. Монгол улсад жендэрийн сөрөг хандлага баттай оршсоор байгаа нь эмэгтэйчүүд, бэлгийн цөөнхийн эсрэг ялгаварлан гадуурхалт, дарамт хүчирхийлэл болон бусад олон

сөрөг үр дагаварт хүргэж байна. Иймд албан боловсролын хөтөлбөрт амьдрах ухааны чадваруудыг тусгах нь нийгэмд тогтсон эдгээр хэм хэмжээг өөрчлөхөд нөлөөлнө. Улмаар, хүчирхийлэл, дарамт, эцгийн эрхт ёсноос үүдэлтэй эрх мэдлийн тэгш бус харилцааны тогтсон хэв шинжийн нөлөөнд өртөж буй залуу эрчүүд, хөвгүүдийг сурган хүмүүжүүлэхэд чухал ач холбогдолтой. Үүний үр дүнд амьдрах ухааны боловсрол эзэмшсэн эдгээр залуучууд хүйсийн тэгш бус байдал, нийгмийн бусад шударга бус байдлыг багасгах өөрчлөлтийн хөдөлгөгч хүч болох боломжтой.

ШХА-ийн зорилго:

Монгол Улсын нийгэм, эдийн засгийн эрх тэгш, тогтвортой хөгжилд хувь нэмэр оруулахыг зорино.

ТӨСЛИЙН ЗОРИЛГО

Амьдрах ухааны чадвартай, эерэг, хариуцлагатай, бие даах чадвартай залуу эрэгтэй эмэгтэйчүүдийг төлөвшүүлнэ.

ХҮЛЭЭГДЭЖ БҮЙ ҮР ДҮН

1. Зорилтот орон нутаг, боловсролын байгууллагуудын залууст чиглэсэн амьдрах ухааны боловсролын хүртээмж нэмэгдсэн байна.
2. Жендэрт суурилсан хүчирхийлэл (ЖСХ)-ээс урьдчилан сэргийлэх загварыг боловсруулж, боловсролын салбарын ажилтанууд ЖСХ-ийг бууруулах, өсвөр үе, залуучуудын дунд эерэг харилцааг дэмжих чадавхитай болсон байна.
3. Сонгосон орон нутгуудад өсвөр үе, залуучуудад ээлтэй бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн үйлчилгээ сайжирч, хамрах хүрээ нь нэмэгдсэн байна.
4. Залуучуудын асуудлаар төрөөс баримтлах бодлого, зан үйлийг өөрчлөх харилцаа, нөлөөллийн стратеги бий болсон байна.

ҮР ДҮН

Монгол Улсын Боловсролын их сургуулиас сургалтын хөтөлбөртөө “Эрүүл мэнд, амьдрах ухаан” хичээлийг оруулж тус сургуульд суралцагч бүх оюутан (3000 оюутан) хоёрдугаар дамжаандаа хоёр кредит цаг суралцах боломжтой болов. Тус төсөл залууст нийгэм сэтгэл зүйн 12 чадварыг олгох багц хичээлийн агуулга, арга зүйгээс бүрдэж байна.

Амьдрах ухааны боловсрол олгох сургалтын үндэсний хэмжээний 25, аймгийн түвшний 324 сургагчийг бэлтгэв. Тэд мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвүүд, ерөнхий боловсролын сургуулиуд, насан туршийн боловсролын төвүүд, их дээд сургуулиуд, Залуучуудын хөгжлийн төвүүд (ЗХТ)-ээр дамжуулан амьдрах ухааны сургалтуудыг залууст хүргэж байна.



Дархан-Уул аймаг дахь
Залуучуудын хөгжлийн төв

Нийт 14 ЗХТ-ийг нээн ажиллуулахаар төлөвлөснөөс 2014 онд төв, орон нутгийн захиргаатай хамтран долоон төвийг баруун аймгуудад албан ёсоор нээлээ. Ингэснээр 2014 оны байдлаар, 15-34 насны нийт 86,207 (44,018 эмэгтэй, 42,189 эрэгтэй) залуучууд ЗХТ-ийн үйл ажиллагаанд хамрагдсан байна. Төвүүд нь амьдрах ухааны сургалт, эрүүл мэнд, ажил эрхлэлт, харилцааны талаар мэдээлэл, зөвлөгөө өгөх, орон нутгийн шийдвэр гаргах үйл явцад залуучуудын оролцоог хангах зэргээр ажиллаж байна.

Хүчирхийллийн эсрэг үндэсний төвөөс ЖСХ-ийн талаар олон нийтийн мэдлэг мэдээллийг дээшлүүлэх зорилготой “Цагаан тууз” кампанит ажлыг өрнүүлээ. Энэхүү ажлыг дэмжсэн Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачлагаар 2013 оны 12 дугаар сард “Хүчирхийллийн эсрэг хамтдаа” сэдэвт хэлэлцүүлэг хийв. Ерөнхийлөгч энэ үеэр хэлсэн үгэндээ нийгэмд хүчирхийлэл газар авч байгааг цохон тэмдэглээд нийгэмд гүн бугшсан энэ асуудлыг хамтран шийдвэрлэхийг бүх талуудад хандан уриаллаа.

Амьдрах ухааны боловсролын хөтөлбөрийн хүрээнд ЖСХ-ээс урьдчилан сэргийлэх сургалтын модуль боловсруулсан.

Эмэгтэйчүүдийн төлөөх ТББ-ын сүлжээ болох МОНФЕМНЕТ ТББ-аас боловсролын орчинд ЖСХ-ээс урьдчилан сэргийлэх жишиг бүрдүүлэх аргачлалыг ТББ-ууд, боловсролын байгууллагууд, олон улсын байгууллагуудтай хамтран боловсрууллаа. Энэхүү “Аюулгүй сургууль” хэмээх аргачлалыг Баян-Өлгий, Завхан, Өмнөговь аймаг, Улаанбаатар хотын Чингэлтэй дүүргийн дөрвөн сургуульд туршиж байна.

Эрүүл мэндийн яам болон холбогдох талууд хамтран Өсвөр үе, залуучуудад ээлтэй эрүүл мэндийн үйлчилгээний анхны Үндэсний стратегийг боловсрууллаа. Түүнчлэн анагаах ухааны сургуулийн оюутнуудад зориулсан Өсвөр үеийн эрүүл мэндэд ээлтэй үйлчилгээний тухай сургалтын гарын авлагыг боловсруулаад байна. Түүнчлэн өсвөр үеийнхэнд ээлтэй долоон клиникийг Улаанбаатар хот, Өмнөговь, Дорноговь аймаг, Өмнөговь аймагт байгууллаа.

Залуучуудын Үе тэнгийн боловсролын (Ү-peer) 14 клуб залууст бэлгийн ба нөхөн үржихүйн боловсрол, эрх, жендэр, БЗДХ/ХДХВ-ын халдвараас урьдчилан сэргийлэх талаар үе тэнгийнхэндээ зөвлөж байна.

Холбоо барих:

Залуучуудын хөгжил төсөл

НҮБ-ын Хүн амын сан, НҮБ-ын байр, НҮБ-ын гудамж 14, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар-14201, Монгол улс;

Утас: 353505;
Факс: 353502
И-мэйл: info@vet-gfa.mn
Вэб хуудас: www.mongolia.unfpa.org

Монгол дахь Швейцарийн ЭСЯ-ны Хамтын ажиллагааны газар

Скай плаза бизнес төв, Олимпын гудамж 12, Сүхбаатар дүүрэг, 1 дүгээр хороо, Улаанбаатар хот

Ш/Х 37, Улаанбаатар 14210, Монгол улс

Утас: +976 11 331 422
Факс: +976 11 331 420
И-мэйл: ulaanbaatar@eda.admin.ch
Вэб хуудас: www.swiss-cooperation.admin.ch/mongolia